



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 272

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин зохион байгуулах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 9,000,000.00 (есөн сая) төгрөгийн балансын үнэ бүхий автомашины нээлттэй дуудлагын худалдааг дахин (3 дахь) зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Ховд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Хүрэлбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2024 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
132001518
15-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 05 дугаар сарын 20 ны өдрийн
122 дугаар тогтоолын хавсралт

ХОВД АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ДАХИН ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр, марк	Улсын дугаар	Арлын дугаар	Үйлдвэрлэсэн он	Ашиглалтанд орсон огноо	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл	Худалдах доод үнэ (төгрөг)	
							Худалдах доод үнэ (өмнөх тогтоолоор)	Худалдах доод үнэ (3 дахь удаагийн)
1	Тоёота карина	18-51 ХОУ	AT2120098677	2001	2012.01.01	9,000,000.00	3,500,000.00	1,750,000.00
Нийт дүн						9,000,000.00 (есөн сая)	3,500,000.00 (гурван сая таван зуун мянган)	1,750,000.00 (нэг сая долоон зуун тавин мянган)